



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024-04-24 № 01/694

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендерийн баримт бичиг  
хянасан тухай

Танай газраас 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан “Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны засварын ажил” НХААГ/20240101068 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Тэргүүн урагшлах” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж үзлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно.” гэж, 17.2.1-т “ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;” гэж, мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн ТШЗ 19.2-т “Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.” гэж тус тус заасан байна.

Захиалагч нь тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.3-т “Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0001312